




МАЛ АЖ АХУЙ, 2024 оны эхний 12 сард

Улаанбаатар


МАЛ ТӨЛЛӨЛТ, БОЙЖИЛТ, 2024 оны эхний 12 сард

■ Бойжуулсан төл

■ Төллөсөн хээлтэгч



ЗҮЙ БУСААР ХОРОГДСОН ТОМ МАЛ, малын төрлөөр, ТОЛГОЙ




Хөдөө аж ахуй-Agriculture



2024 онд жилийн эцсийн мал тооллогоор нийт мал 1970133 толгой болсон нь өнгөрсөн оны мөн үеэс 91.8 мянган толгойгоор буюу 3.5 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Тэмээн сүрэг 148215 толгой, адуун сүрэг 84928 толгой, үхэр сүрэг 25230 толгой, хонин сүрэг 541460 толгой, ямаан сүрэг 1170300 толгой тоологдсон байна.

ЗУРАГ 21. МАЛЫН ТОО, оноор, жилийн эцсийн байдлаар



2024 оны эцэст 6105 малчин өрх байгаа нь өнгөрсөн оноос 2.2 хувиар буюу 141 өрхөөр буурсан байна. Тооллогоор суудлын авто машинтай малчин өрх-3842, мотоциклтой малчин өрх- 3624, трактортой малчин өрх-10, гар утастай малчин өрх-6058, цахилгааны эх үүсгүүртэй малчин өрх- 5008, телевизортой 4646 малчин өрх тоологдсон байна.

ЗУРАГ 22. МАЛЧИН ӨРХИЙН ТОО, МАЛЫН ТОО, байршлаар, жилийн эцсийн байдлаар



Малтай өрхийн тоо 7535 болж өмнөх оноос 152 (3.8%) өрхөөр буурсан. Малын тоогоор бүлэглэж үзэхэд 1000-аас дээш малтай өрх 14 (6.8%), 501-999 малтай өрх 43 (3.9%), 51-200 малтай өрх 47 (2.2%) тус тус буурч, 50 хүртэл малтай өрх 83 (5.7%) өссөн байна.

Малчдын зарим мэдээлэл


2024 оны жилийн эцсийн мал тооллогоор аймгийн хэмжээнд 191 мянгат малчин тоологдсон байна. 2024 оны жилийн эцэст 9079 малчин тоологдсоноос 42.5 хувь нь эмэгтэй малчид байна. Нийт малчдын 43.3 хувь нь зээлтэй бөгөөд зээл авсан малчдын 21.2 хувийг 25-34 насны, 23.8 хувийг 35-44 насны, 29.1 хувийг 45-54 насны малчид эзэлж байна.

ЗУРАГ 23. МАЛЧДЫН МЭДЭЭЛЭЛ, тоо, 2024 оны жилийн эцсийн байдлаар



2024 оны жилийн эцсийн мал тооллогоор малчдын тоо 9079 байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 337 (3.5%) хүнээр буурсан үзүүлэлттэй байна. Аймгийн хэмжээнд гурвантэс сум хамгийн их 834 малчидтай байна.

ЗУРАГ 24. МАЛЧДЫН ТОО, 2024 оны жилийн эцсийн байдлаар



Хамгийн олон малтай сумаар Ханхонгор 199213, Номгон 186397, Мандал-Овоо 179047, Манлай 165426, Булган 153785 толгой мал тус тус тоолуулсан байна. Малын таван төрлөөр нь авч үзвэл тэмээгээр Ханбогд сум 29186, адуугаар Манлай сум 10406, үхрээр Ханбогд сум 4689, хониор Ханхонгор сум 68436, ямаагаар Номгон сум 136450 толгойгоор тус тус тэргүүлж байна.

ЗУРАГ 25. МАЛЫН ТООГООР ТЭРГҮҮЛЖ БАЙГАА СУМД, төрлөөр, 2024 оны жилийн эцсийн байдлаар



Мал	Манлай	10406	Ханбогд	29186	Ханбогд	4689	Ханхонгор	68436	Номгон	136450
Цогтцэций	9375	МандалОвоо	23677	Булган	2404	Манлай	63672	Ханхонгор	112324	
Ханхонгор	7991	Манлай	14805	Баяндалай	2326	Мандал-Овоо	54655	Гурвантэс	109215	
Ханбогд	7517	Цогт-Овоо	12363	Манлай	2043	Булган	53952	Мандал-Овоо	932423	
Булган	6629	Ханхонгор	8502	Ханхонгор	1960	Цогтцэций	52577	Булган	83682	

Аймгийн хэмжээгээр оны эхний төллөвөл зохих 1067.7 мянган хээлтэгчийн 12.8 хувь нь буюу 162.1 мянган хээлтэгч төллөж, гарсан төлийн 88.4 хувь буюу 143.3 мянган төльбойжсон байна. 2024 онд том малын зүй бус хорогдлоор 169640 толгой мал хорогдож, өнгөрсөн оны мөн үеэс 159.0 мянган толгой буюу 15.9 дахин өссөн байна. Аймгийн хэмжээгээр нийт малтай өрх 7687 байгаагийн 6246 нь малчин өрх байна.

ЗУРАГ 26. МАЛ СҮРГИЙН БҮТЭЦ, 2023 оны жилийн эцсийн байдлаар



Газар тариалангийн салбарт аймгийн хэмжээнд 2024 оны жилийн эцсийн байдлаар нийт 55.2 га-гаас 368.0 тонн төмс, 90.2 га-гаас 645.5 тонн хүнсний ногоо, тэжээлийн ургамал 17.7 га-гаас 32.6 тонн тус тус хураан авсан байна. Өмнөх оны мөн үеийн ургац хураалтаас төмс 55.8 тонноор буюу 13.1 хувиар, хүнсний ногоо 25.0 тонноор буюу 3.7 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна.

ЗУРАГ 27. ХУРААСАН УРГАЦ, төрлөөр, тонн, жил бүрийн жилийн эцсийн байдлаар

